

Г.Базарваань- ДХИС-ийн Удирдлагын академийн
Аюулгүй байдлын удирдлага, стратеги
профессорын багийн профессор,
доктор, цагдаагийн дэд хурандаа
А. Баярмаа-магистрант, дэслэгч

“АЮУЛГҮЙ БАЙДАЛ”-ЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН АСУУДАЛ

Абстракт: Энэхүү илтгэлд Аюулгүй байдал судлалын шинжлэх ухааны үүсэл хөгжил, онол арга зүйн асуудлыг хөндөж, цаашдын чиг хандлагын талаарх судлаачийн байр суурийг илэрхийлэх болно.

Түлхүүр үг: Аюул, аюулгүй байдал, зүй тогтол, хөгжил, хавсарга шинжлэх ухаан

ОРШИЛ: Нийгмийн хөгжлийн зүй тогтол, хөгжил дэвшил шинжлэх ухааны уламжлалт салбаруудыг өөр хооронд нь нэгтгэж улмаар шинжлэх ухааны шинэ салбарыг үүсгэж байна. Үүний нэг бол аюулгүй байдал судлалын шинжлэх ухаан болно.

Аюулгүй байдлын тухай ухагдахуун Өрнөдийн соёл иргэншилд XVII зуунд нэвтэрсэн гэж үздэг. Тухайлбал, Европ тивийг 30 жилийн турш сүйтгэсэн дайн 1648 онд дуусч энхийн гэрээг Мюнстер, Оснабрюк хотод байгуулсан байдаг. Гэрээнд хэд хэдэн асуудал туссаны дотор улс орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх явдал үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн зарчим байхыг онцолсон аж. Энэхүү зарчим “Вестфалийн гэрээний зарчим” хэмээн түүхэнд үлдэж, төрт улс хэмээх ойлголтыг бий болгосон төдийгүй улс төрийн реализмын хөгжлийн түлхүүр болжээ¹.

Аюулгүй байдлыг хангах асуудал хүн, нийгэм, улс гүрэн, дэлхийн хамтын нийгмийн үйл хэрэгт тулгардаг. Өөрөөр хэлбэл, амьд ертөнц, хүн төрөлхтний хөгжил дэвшилд заналхийлж болзошгүй бүхий л аюулыг судалж, илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах, таслан зогсоох, устгахад аюулгүй байдлын чиглэлээр судалгаа хийх, ажиллах хүн бүр ухаанаа уралдуулах учиртай. Иймд аюулгүй байдлыг хангах шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай юм. Аюулгүй байдал судлалын шинжлэх ухаан хавсарга шинжлэх ухааны хувьд хөгжиж бэхжсэн бусад шинжлэх ухааны ололтод тулгуурлан хөгжих зүй тогтолтой болно.

Илтгэлд аюулгүй байдал судлалын шинжлэх ухааны онол, арга зүйн хөгжлийн талаар өгүүлж, энэхүү хавсарга шинжлэх ухааны ирээдүйн чиг хандлагыг тодорхойлохыг зорино.

¹Contemporary security studies. Alan Collins. 2006. page 16.

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНОЛ АРГА ЗҮЙН АСУУДАЛ

Аюулгүй байдлын үүсэл, хөгжил өнө эртнээс эхлэлтэй. Хүний аюулгүй байдлын асуудал ерөөс түүний гарвал үүсэлтэй холбоотой байдаг. Түүний хөгжил, хувьслыг бүр хүй нэгдлийн үеэс эхлэн авч үзэх нь бий. Гэвч “аюулгүй байдал” гэдэг нэр томъёо болон түүний агуулгын тухай өнөөг хүртэл нийтээр хүлээн зөвшөөрсөн ойлголт, онолын суурь тогтоогүй байна. Учир нь аюулгүй байдал гэх ухагдахууны хамрах хүрээ улам бүр өргөжиж буйтай холбоотой болно. Өмнө нь аюулгүй байдал судлалын үндсэн судлагдахуун зөвхөн цэрэг-улс төр, батлан хамгаалах асуудлыг хамарч байсан бол эдүгээ түүний хүрээ улам бүр тэлэх болж, уламжлалт бус аюулгүй байдлын асуудал уг шинжлэх ухааны чухал судлагдахуун болсон байна. Тухайлбал, эдүгээ хүн төрөлхтөн хүрээлэн буй орчны өөрчлөлтөөс үүсэх аюулаас эхлээд эдийн засгийн, мэдээллийн зэрэг олон аюулгүй байдлын асуудалтай тулгарч байна. Эдгээр шинэ төрлийн аюулыг товчид нь аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг гэнэ. Үүнээс үзвэл аюулгүй байдал судлалын түгээмэл судлагдахуун бол аюул, занал байх аж.

Аюулыг оршин буй болон илэрч байгаа орон зайгаар гадаад, дотоод, түүнд өртөж буй объектоор хувь хүн, иргэн, байгууллага, орон нутаг, улс үндэстэн, бүс нутаг болон даян дэлхийд тулгамдах аюул гэж ангилж болно. Мөн судлах түвшингөөр тусгай салбарын, улс төрийн харилцааны болон философийн гэж хувааж үздэг болно.

Тусгай салбарын гэдэг тусгайлсан чиг үүргийн байгууллага /тагнуул, дипломат төлөөлөгчийн газрын мэдээ/-аас ирүүлсэн мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийх бөгөөд гол төлөв мэдээллийн, эдийн засгийн, гадаад болон дотоод аюулгүй байдлын асуудлыг хамаардаг. Улс төрийн харилцааны гэдэг аливаа улс хоорондын харилцаанд баримтлах бодлого, шахалт, хөшүүргийн асуудлыг хөндөж гол төлөв оршин тогтнохуйн аюулгүй байдлын асуудлыг хамаардаг. Харин улс орны бүхий л аюулгүй байдлын асуудлыг цогцоор харж, аюулгүй байдлын стратегийг боловсруулах судалгааг философийн түвшний судалгаа гэдэг аж. Энэ утгаараа философийн түвшний судалгаанд тусгай салбарын болон улс төрийн харилцааны судалгааны түвшин багтах юм¹.

Аюулгүй байдал судлалд түгээмэл ашиглах хоёр үндсэн онолын сургууль бий. Үүнд:

Реалист онол. Онолын гол ойлголт бол Олон улсын харилцаа өөрөө анархи, амиа авч гарах орчин тул төр улс өөрийн оршин тогтнох, өөрийгөө авч үлдэхэд л гол анхаарлаа хандуулах ёстой. Төрийн бүрэн эрхт байдал хамгийн чухал бөгөөд дотооддоо хууль ёсоор хүч хэрэглэдэг дээд эрхтэй байгууллагатай бол гадааддаа гадны ямар эрх мэдэл, хяналтаас ангид байх ёстой хэмээн сургадаг. Иймээс төр улсад үндэсний эрх ашиг хамгийн чухал

¹ Аюулгүй байдлын эволюци ба Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Стратегийн судалгаа сэтгүүлийн 2014 оны 71 дүгээр дугаар, хуудас 85.

бөгөөд энэ нь эрх мэдэл, хүч чадалд оршдог аж. Энэ онолын сургаалиар төрийн аюулгүй байдал, оршин тогтнол хамгийн чухал зорилт байдаг. Төр олон улсын харилцааны хамгийн гол тоглогч бөгөөд үр ашгийг хамгийн өндөр байлгаж, зарцуулах эрч, зардлыг нэмэгдүүлэх рационал, нэгдмэл үйлдэгч мөн. Тиймээс төрийн бус оролцогчид ялангуяа сонирхлын бүлэг, олон улсын байгууллага, улс дамнасан корпорацийн ач холбогдлыг ямагт бууруулж үздэг байв. Гэвч орчин үед эдийн засгийн хүчин чадавх улс орны аюулгүй байдал гойд нөлөөлөх болсон. Иймээс үндэстэн дамнасан корпорацийг их гүрнүүд реалист бодлогоо хэрэгжүүлэхдээ ашиглах болсноор олон улсын эдийн засгийн байгууллага, сан, нийгэмлэгийн үндсэн чиг үүрэг улам бүр өөрчлөгдөж байна.

Энэ нь реалистууд төр улсын харьцангуй хожооны тухай санаанд гол ач холбогдол өгөх болсон буюу өөрийн байр сууриа илүү бэхжүүлэхийг чухалчлах болсонтой холбоотой. Үүнийг ОУВС, Дэлхийн банк, Дэлхийн худалдааны банк зэрэг олон улсын байгууллагыг их гүрнүүд /АНУ, БНХАУ, Англи/ өөрийн ашиг сонирхлоо хамгаалахын тулд ашиглах хэрэгсэл болгож байна.

Түүнчлэн уг онолоор олон улсын харилцаа өөрөө өөртөө туслах, өөрийгөө хамгаалах цорын ганц нөхцөл байдаг учраас улс болгон өөрийн аюулгүй байдал, оршин тогтнохуйн төлөө бүхий л зүйлээ зориулах ёстой аж. Үүнээс “Аюулгүй байдлын дилемма” үүсдэг буюу нэг улс аюулгүй байдлаа баталгаажуулах, бэхжүүлэх үйл явц нөгөө улсад аюул, түгшүүр бий болгодог. Үүнтэй холбоотойгоор эмээж буй улс аюулгүй байдлаа бэхжүүлэх шаардлагыг өсгөдөг. Нэг улс зэвсэглэлээ нэмэгдүүлэх явдал бусад улсад түгшүүр төрүүлснээр нийтээрээ зэвсэглэлээр хөөцөлдөх нөхцөлийг бүрдүүлдгийг өнөөгийн олон улсын амьдрал харуулж байна. Реалист онолыг товчоор “хүчгүй нь хүчтэйнхээ өмнө буруутай” гэж ойлгож болно.

Либерал онол. АНУ-ын ерөнхийлөгч асан В.Вильсон энэхүү онолыг үндэслэгч гэж үздэг. Философийн хувьд идеализмын суурин дээр хөгжсөн, хүний эрх чөлөөг дээдэлж, төрийн оролцоог хязгаарлах, ардчилалыг бэхжүүлэх, чөлөөт эдийн засгийн харилцааг хөгжүүлж хамтын үр ашигт хүрэхийг сургах онолын сургууль. Либерализмын онолыг тогтолцооны хувьд амьдралд хэрэгжүүлсэн анхны тохиолдол бол 1776 оны Америкийн хувьсгал, 1789 оны Францын хувьсгал болно. Онолын гол суурь нь дэлхийн хамтын нийгэмлэгийг бий болгож улс бүрийн тэгш оролцоо, аюулгүй байдлыг хангана гэж үздэг. Энэхүү онолын үндсэн дээр “Үндэстнүүдийн лиг”¹, хожим НҮБ, НАТО, Европын холбоо зэрэг, хамтын аюулгүй байдал, эдийн засгийн нийгэмлэгүүд бий болсон юм.

Эдүгээ НҮБ-ын гишүүн улс орны дийлэнх ардчилал, хүний эрх, эрх чөлөө, зах зээлийн чөлөөт эдийн засгийг хөгжлийнхөө чиг баримжаа хэмээн үзэх болсноос үзвэл либерализм дэлхийн ихэнх оронд онол, практикийн хувьд

¹ 1920 оны 01 дүгээр сарын 20-ний өдөр байгуулсан, олон улсын харилцаа, хамтын ажиллагааны анхны олон улсын байгууллага. Энэ байгууллагыг өнөөгийн НҮБ-ын суурийг тавьсан гэж олон улсын харилцаа судлалын түүхэнд тэмдэглэсэн байдаг.

ялсан гэж үзэх үндэслэлтэй. Гэвч олон улсын харилцаанд “хүйтэн дайн”-ы шинэ үе шатад тогтсон нэг туйлт буюу нэг жанжинт тогтолцоо ганхаж, хүчний тэнцвэрийн шинэ хуваагдал үүсэж, олон туйлт тогтолцоот олон улсын амьдралын өвөрмөц дэг журам тогтож буйтай зэрэгцэн дэлхийн улс орноос аль нь ч бэлтгэлгүй байсан Ковид-19 цар тахлын буюу вирусын хямралын үед улс орон бүр өөрийн аюулгүй байдал, эрх ашиг, ашиг сонирхлоо хамгаалах бодлого явуулах болсонтой холбоотойгоор том жижиг гэлтгүй бүхий л улс реалист онолыг баримтлах болж байна.

Үүнийг АНУ-ын “Эн тэргүүнд Америк”¹, ОХУ-ын “Орос ертөнц”², БНХАУ-ын “Бүс ба зам”, Франц олон Их Британы “Бие даасан атлантизм” болон Энэтхэгийн “Эдийн засгийн бие даасан байдал”³ зэрэг гео-эдийн засаг, геополитик, стратегийн томоохон бодлого болон вакцины төлөөх тэмцлээс харж болно. Эдгээр бодлого цаашид олон улсын амьдралд либерал-реализмаас реалист-реализм руу шилжих эхлэлийг тавьж байна.

Онолын хувьд аюулгүй байдлыг реализм буюу батлан хамгаалах хүчин чадавх, конституционал буюу либерализмийн эрх зүйт хандлагаар хангадаг. Өөрөөр хэлбэл, улс орон батлан хамгаалах үндэсний тогтолцоог хөгжүүлэхийн зэрэгцээ олон улсын болон дотоод эрх зүйн систем нь тухайн улсын аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх ёстой гэж үздэг. Гэвч энэ онолоор аюулгүй байдлаа хангаж чадах улс манай гаригт АНУ, ОХУ, БНХАУ, БНФУ, ИХ Британи болон БНЭУ зэрэг цөөхөн улс бий. Иймээс улс орон бүр аюулгүй байдлаа хангах гарцаагүй нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө тэмцэлдэх болно. Үүнээс олон улсын амьдралд цаашид либерал-реализмаас реалист-реализмын онол руу шилжинэ хэмээн таамаглаж болно.

Үүний сацуу аюулгүй байдал судлалын онолын өнөөгийн чиг хандлага цаашид дэлхий нийтээрээ аюулгүй байдлыг хангах хийсвэр онолын ойлголт болох либерализм, плюрализм /pluralism/-ыг халж олон улсын харилцаанд улс орнууд эргээд уламжлалт аюулгүй байдлын ухагдахуун /цэрэг-улс төр, батлан хамгаалах хүчин чадавх/-аар аюулгүй байдлаа хангах тогтолцоонд шилжинэ хэмээн таамаглахад хол зөрөхгүй болов уу.

Аюулгүй байдлын тухай ойлголт ихээхэн цогц шинжтэй, юмс үзэгдлийн мөн чанарыг тайлж, тодорхойлохоос эхлэх учиртай байна. Хэдийгээр эдийн засаг, улс төр, байгаль орчин, цэргийн ухаан тус бүртээ өөрийн шинжлэх ухаантай байдаг ч шинжлэх ухааны эдгээр салбар бүхэн аюулгүй байдлын ерөнхий онолыг боловсруулахад өөр өөрийн хувь нэмрийг оруулах зүй тогтолтой. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдлын хувьд эдийн засаг, цэрэг, улс төр, геологи, газарзүй, мэдээлэл, боловсрол, шашин, хүн амзүй, генетик зэрэг судлагдахуунг тусгайлан авч үзэх боломжгүй, зөвхөн цогцоор нь судлах өвөрмөц онцлогийг улам бүр өөртөө агуулж байна.

Аюулгүй байдал судлалын шинжлэх ухааны онол, судлагдахууны олон талт байдалд тулгуурлаж Өрнөдийн эрдэмтэд шинжлэх ухааны бүхий л

¹ *America first*

² *Русский мир*

³ *Economical autonomie*

асуудлыг хамруулан уг шинжлэх ухааныг “секюритилоги” буюу аюулгүй байдал судлал хэмээн нэрлэсэн явдал учир зүйн хувьд зөв томъёолол болно.

Аюулгүй байдлын судалгааны объект улс гүрэн, нийгэм хамт олон, иргэдийг бүхэлд нь багтаасан хүний амьдрал байдаг тул өөрийнхөө аюулгүй байдал, тэрчлэн амьдралыг тэтгэгч дэлхий, түүнийг хүрээлэн байгаа агаар мандалын орон зай, байгаль, орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлж буй дэлхийн хамтын нийгэмлэгийн бүхий л үйл ажиллагааг судалдаг байна.

Түүнчлэн аюулгүй байдлын судалгаа илэрч байгаа болон үүсэж болзошгүй аюулын мөн чанар, гарал үүсэл, хамрах хүрээ, өрнөл, цаашдын үр нөлөөг таамаглал дэвшүүлж, хамгийн боломжит хариу үйлдлийг боловсруулдаг онцлогтой. Аюулыг тархаах үйлдэл бол эрсдэл юм. Өөрөөр хэлбэл, аюулыг хумихаар боловсруулсан судалгаа, авч хэрэгжүүлсэн хариу үйлдэл, таамаглалын дагуу бус, үр дүнд хүрээгүй байх явдал өөрөө аюул дагуулах эрсдэл болно.

Судлаачдын бүтээлээс үзэхэд эрсдэлийн тухай ойлголт мөн л нэг мөр болоогүй, өөр өөрийн үзэл баримтлалаар тодорхойлж байна. Аюулгүй байдал болон эрсдлийн тухай нэгдсэн ойлголт одоо хэр бий болоогүй явдал аюул эрсдлийн төрөл зүйл нийгэм, техник, технологи, байгаль цаг уур, экологийн өөрчлөлтөөс шалтгаалж ямагт өөрчлөгдөж байдагтай холбоотой байна.

Аюулгүй байдлын судалгааны арга зүйн үндсэн зарчим бол системийн буюу тогтолцооны зарчим байдаг. Системийн зарчим философийн утгаараа бүхэл болон хэсгийн харьцаан дээр тогтдог. Мэдээж шинжлэх ухааны зүй тогтлоор юмс үзэгдлийн холбоо хамаарлыг судлах үндсэн арга зүйг агуулна. Энэ утгаараа юмс үзэгдэл зайлшгүй холбоотой байдагтай адил аюулгүй байдал судлал аюулгүй байдлыг зайлшгүй хангах зорилготой байдаг. Үүнийг өөрөөр “баталгаатай хангагдсан” байдал гэнэ.

Арга, арга зүй, аргачлалын талаас авч үзвэл аюулгүй байдал судлал нийгмийн харилцаанд учирч буй бүхий л аюул, заналын эх үүсвэр чухам юунд оршиж буйг тайлж, тайлбарлахад чиглэдэг. Гэвч бодит байдалд улс орны аюулгүй байдлыг төрийн удирдлагын түвшинд хангахад улс төрчдийн субьектив нөлөө, үйл явдлын өрнөлд түлхүү анхаардаг явдал дээр дурдсан “баталгаатай хангагдсан” байдлыг хангасан мэт харагдах хэлбэрийг үүсгэх ч аюул, заналыг нөхцөлдүүлж байгаа учир шалтгаан, мөн чанарыг олж тогтоох асуудал орхигдох тал бий.

Иймээс аюулгүй байдал судлалыг хөгжүүлэхийн тулд аюулгүй байдал судлалын хүрээлэн, тинк танк байгууллагыг Засгийн газар, ҮАБЗ эсвэл ЗХЖШ харьяанд бус, бие даасан байдлаар хөгжүүлж, төр засгаас аюулгүй байдлын асуудлаар шийдвэр гаргах тохиолдолд хараат бус судалгааны байгууллагын хөндлөнгийн дүгнэлт, судалгааг авч үзэх, сонсох хэрэгтэй нь олон улсаас Ковид-19-ийн цар тахлын үед түүний аюул эрсдлийг тооцох, тархалтаас сэргийлэх, хумих зэргээр төр засгуудаас явуулж буй удирдлагын шийдвэр, хариу үйлдлээс харж болохоор байна.

Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа хойш үлэмж олон аюултай тулгарч байсан хэдий ч түүхэн хөгжлийнхөө явцад бүхий л аюулыг гэтэлж, даван туулж, арилгаж, гайхам амжилт олж түүнийгээ батган бэхжүүлэхэд дан ганц хүний оюун ухаан голлох үүрэгтэй байсныг тэмдэглэж энэхүү илтгэлээ өндөрлөө.

Дүгнэлт

“Аюулгүй байдал” гэдэг нэр томъёо болон түүний агуулгын тухай өнөөг хүртэл нийтээр хүлээн зөвшөөрсөн ойлголт, онолын суурь тогтоогүй байна. Учир нь аюулгүй байдал гэх ухагдахууны хамрах хүрээ улам бүр өргөжиж байна.

Орчин үед эдийн засгийн хүчин чадавх улс орны аюулгүй байдал гойд нөлөөлөх болсон. Иймд үндэстэн дамнасан корпорацийг их гүрнүүд реалист бодлогоо хэрэгжүүлэхдээ ашиглах болсноор олон улсын эдийн засгийн байгууллага, сан, нийгэмлэгийн үндсэн чиг үүрэг улам бүр өөрчлөгдөж байна. Үүнийг ОУВС, Дэлхийн банк, Дэлхийн худалдааны банк зэрэг олон улсын байгууллагыг их гүрнүүд /АНУ, БНХАУ, Англи/ өөрийн ашиг сонирхлоо хамгаалахын тулд ашиглах хэрэгсэл болгож байгаагаас харж болно.

Олон улсын харилцаанд “хүйтэн дайн”-ы шинэ үе шатад тогтсон нэг туйлт буюу нэг жанжинт тогтолцоо ганхаж, хүчний тэнцвэрийн шинэ хуваагдал үүсэж, олон туйлт тогтолцоот олон улсын амьдралын өвөрмөц дэг журам тогтож буйтай болон дэлхийн улс орноос аль нь ч бэлтгэлгүй байсан Ковид-19 цар тахлын буюу вирусын хямралын үед улс орон бүр өөрийн аюулгүй байдал, эрх ашиг, ашиг сонирхлоо хамгаалах бодлого явуулах болсонтой холбоотойгоор том жижиг гэлтгүй бүхий л улс реалист онолыг баримтлах болж байна. Энэ нь цаашид олон улсын амьдрал либерал-реализмаас реалист-реализм руу шилжих эхлэлийг тавьж байна.

Аюулгүй байдал судлалын шинжлэх ухааны онол, судлагдахууны олон талт байдалд тулгуурлаж Өрнөдийн эрдэмтэд шинжлэх ухааны бүхий л асуудлыг хамруулан уг шинжлэх ухааныг “секюритилоги” буюу аюулгүй байдал судлал хэмээн нэрлэхийг оновчтой гэж үздэг нь учир зүйн хувьд зөв томъёолол болно.

Аюулгүй байдал судлалыг хөгжүүлэхийн тулд аюулгүй байдал судлалын хүрээлэн, тинк танк байгууллагыг Засгийн газар, ҮАБЗ эсвэл ЗХЖШ харьяанд бус бие даасан байдлаар хөгжүүлж, төр засгаас аюулгүй байдлын асуудлаар шийдвэр гаргах тохиолдолд хараат бус судалгааны байгууллагын хөндлөнгийн дүгнэлт, судалгааг авч үзэх, сонсох хэрэгтэй нь олон улсаас Ковид-19-ийн цар тахлын үед түүний аюул эрсдлийг тооцох, тархалтаас сэргийлэх, хумих зэргээр төр засгуудаас явуулж буй удирдлагын шийдвэр, хариу үйлдлээс харж болохоор байна.